



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/09

Жавхлант

Бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 (төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай), 2023 оны 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, 5 дугаар хавсралт, 6 дугаар хавсралт, 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. 2026 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон тоог 1 дүгээр, Засаг даргын Тамгын газрын орон тоог 2 дугаар, Эрүүл мэндийн төвийн орон тоог 3 дугаар, Соёлын төвийн орон тоог 4 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төсөвт байгууллагуудын батлагдсан бүтэц, орон тоог мөрдөж ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Т.Эрдэнэцэцэг), Төсөвт байгууллагуудын Нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР

Сумын Засаг даргын 20 16 оны 11 дүгээр
сарын 21 ний өдрийн 11 тоот
захирамжийн 1 хавсралт



СОЁЛЫН ТӨВИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Соёлын төв	Албан тушаалын нэр	Тоо
1	Удирдах ажилтан - 1	Дарга	1
2	Гүйцэтгэх ажилтан - 5	Дуу хөгжмийн багш	1
		Бүжгийн багш	1
		Номын санч	1
		Орон нутаг судлах танхимын ажилтан	1
		Техникийн ажилтан	1
3	Үйлчлэх ажилтан	Үйлчлэгч	1
Нийт орон тоо – 7			